

СБХ, Төрийн Оосго
Түвшинч 11/13



Салхуу

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 29 өдөр

Дүгээр 199

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг үндэслэн, "Диспетчерийн үндэсний төв" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд, Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Цахилгаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төлөх диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан диспетчерийн үйлчилгээний төлбөр буюу тарифын дагуу "Диспетчерийн үндэсний төв" ХХК /Д.Балдорж/-тай аж ахуйн гэрээ байгуулж, 2016 оны 11 болон 12 дугаар саруудад мөрдөн ажиллахыг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК /Д.Баярсайхан/, "Эрдэнэтбулганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК /Г.Баярцогт/, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК /Ш.Доржрагчаа/, "Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК /С.Нэргүй/, "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК /Д.Бямба-Очир/, "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК /Д.Гантуул/, "Клин-Энержи" ХХК /Ц.Сүхбаатар/, "М Си Эс интернейшнл" ХХК /Ч.Даваахүү/, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК /Г.Отгонбаатар/, "Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК /Г.Жаргалсайхан/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчулуун/-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



А.ТЛЕЙХАН

Д.БАССАЙХАН

Э.ТҮВШИНЧУЛУУН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн
199 дүгээр тогтоолын хэвсрэлт

**ЦАХИЛГААН ҮЙЛДВЭРЛЭХ, ТҮГЭЭХ, ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧДЭЭС ТӨЛӨХ ДИСПЕТЧЕРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР БУЮУ ТАРИФ**

1. Диспетчерийн үйлчилгээний төлбөр буюу тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Үйлчилгээний төлбөр буюу тариф /мянган төгрөг/ 2016 он
1	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	1,940,042.3
2	"Эрдэнэтбулганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	1,158,388.1
3	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	283,055.9
4	"Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК	329,725.2
5	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК	576,585.7
6	"Дарханы дулааны сүлжээ" ТӨХК	46,008.7
7	"Клин-Энержи" ХХК	198,367.2
8	"М Си Эс интернейшнл" ХХК	74,589.2
9	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	49,681.5
10	"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	27,308.6
Нийт дүн		4,683,752.5

